

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/39/-НА-СТА-ТШЗ
ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/405
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020357

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,616,864.66	86,619,946.66
33	АВЛАГА	17,905,800.00	23,000,000.00
335	Бусад авлага	17,905,800.00	23,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	17,905,800.00	23,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,711,064.66	63,619,946.66
354	Хангамжийн материал	58,711,064.66	63,619,946.66
35420	Аж ахуйн материал	52,555,064.66	48,219,946.66
35470	Бусад хангамжийн материал	6,156,000.00	15,400,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,197,750,391.39	10,845,700,113.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,197,750,391.39	10,845,700,113.91
392	Биет хөрөнгө	12,142,596,279.96	10,790,766,002.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,807,037,430.37	1,567,601,682.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	-467,508,164.90	-565,475,240.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	251,773,600.00	252,173,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-179,561,512.77	-173,377,139.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,731,045.00	165,781,520.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85,404,463.12	-102,475,926.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,519,577.00	62,835,077.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,211,621.76	-46,139,109.32
39209	Зам, гүүрийн байгууламж	10,674,041,626.00	10,674,041,626.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-147,114,050.03	-1,198,079,849.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	191,992,534.00	230,731,534.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-75,719,719.83	-98,669,973.07
39217	Ном	20,000.00	21,818,200.00
393	Биет бус хөрөнгө	55,154,111.43	54,934,111.47
39303	Бусад биет бус хөрөнгө	64,328,000.00	64,328,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-9,173,888.57	-9,393,888.53
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,274,367,256.05	10,932,320,060.57
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,274,367,256.05	10,932,320,060.57
51	Засгийн газрын хувь оролцоо	12,274,367,256.05	10,932,320,060.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	733,779,241.53	733,779,241.53
51101	Өмч: - төрийн	733,779,241.53	733,779,241.53
512	Хуримтлагдсан үр дүн	11,158,939,284.29	9,816,980,667.11
51210	Өмнөх үеийн үр дүн	11,158,939,284.29	11,159,027,862.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,342,047,195.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,648,730.23	381,560,151.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,274,367,256.05	10,932,320,060.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,247,224,925.80	756,824,517.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,595,175,378.00	92,117,890.04
120	Нийтлэг татварын бус орлого	10,595,175,378.00	92,117,890.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,595,175,378.00	92,117,890.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,595,175,378.00	92,117,890.04
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,585,175,378.00	63,089,550.04
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	29,028,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	652,049,547.80	664,706,627.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,504,547.80	157,148,627.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,885,350.00	80,750,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,725,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,316,697.80	22,290,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,877,500.00	54,107,877.70
131106	Төсвийн урамшуулал	12,700,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	513,545,000.00	507,558,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,545,000.00	507,558,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	756,193,415.78	1,840,579,412.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	706,073,715.78	1,834,589,412.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	673,451,694.75	1,781,365,534.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,570,466.78	263,217,100.00
210101	Үндсэн цалин	242,073,666.78	177,591,043.00
210102	Нэмэгдэл	12,006,300.00	48,025,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,490,500.00	37,601,057.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,428,066.63	34,440,037.03
210201	Тэтгэврийн даатгал	22,966,173.63	23,888,837.99
210202	Тэтгэмжийн даатгал	2,615,474.00	2,637,949.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,092,378.00	2,374,039.44
210204	Ажилгүйдлийн даатгал	523,094.00	659,609.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,230,947.00	4,879,600.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,288,200.00	56,642,053.91
210301	Гэрэл, цахилгаан	11,337,557.00	11,177,645.91
210302	Түлш, халаалт	48,700,643.00	45,214,408.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,938,600.00	54,233,984.63
210401	Бичиг хэрэг	5,809,360.00	4,545,810.00
210402	Тээвэр, шатахуун	28,783,829.00	32,093,687.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,033,840.00	2,207,619.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	3,657,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	513,100.00	00.00
210408	Бараа материал ахталсны зардал	8,798,471.00	11,729,468.00
2105	Нормативт зардал	771,680.00	700,602.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	771,680.00	700,602.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,215,200.00	5,312,900.00
210604	Урсгал засвар	10,215,200.00	5,312,900.00
2107	Томилолт, зочны зардал	3,299,000.00	2,258,000.00
210702	Дотоод албан томилолт	3,299,000.00	2,258,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,099,489.00	31,544,048.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,699,169.00	30,096,375.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	392,400.00	497,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	475,920.00	353,198.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250,840,992.34	1,333,016,808.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,462,127.94	96,148,216.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	171,378,864.40	1,236,868,592.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,622,021.03	53,223,878.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,495,450.00	19,024,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,415,500.00	17,037,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,079,950.00	1,987,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,126,571.03	34,198,978.13
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,119,700.00	5,990,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50,119,700.00	5,990,000.00
220001	Барилга байгууламж	00.00	4,545,000.00
221001	Их засвар	00.00	846,000.00
223001	Бусад хөрөнгө	50,119,700.00	599,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,491,031,510.02	-1,083,754,895.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	713,751.08	258,292,300.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	443,751.08	1,030,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	270,000.00	257,262,300.48
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-713,751.08	-258,292,300.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,490,317,758.94	-1,342,047,195.48

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	733,779,241.53	381,753,892.29	668,516,363.29	00.00	1,784,049,497.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	105,162.06	00.00	105,162.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.53	381,753,892.29	668,621,525.35	00.00	1,784,154,659.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-105,162.06	00.00	00.00	-105,162.06
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,490,317,758.94	00.00	10,490,317,758.94
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.53	381,648,730.23	11,158,939,284.29	00.00	12,274,367,256.05
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	733,779,241.53	381,648,730.23	11,158,939,284.29	00.00	12,274,367,256.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	88,578.30	00.00	88,578.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.53	381,648,730.23	11,159,027,862.59	00.00	12,274,455,834.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-88,578.30	00.00	00.00	-88,578.30
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,342,047,195.48	00.00	-1,342,047,195.48
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.53	381,560,151.93	9,816,980,667.11	00.00	10,932,320,060.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	652,049,547.80	664,706,627.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	652,049,547.80	664,706,627.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,504,547.80	157,148,627.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,885,350.00	80,750,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,725,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,316,697.80	22,290,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,877,500.00	54,107,877.70
131106	Төсвийн урамшуулал	12,700,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	513,545,000.00	507,558,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,545,000.00	507,558,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	543,992,147.80	599,713,072.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	543,992,147.80	599,713,072.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,378,376.77	546,476,401.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,217,099.24	263,217,100.00
210101	Үндсэн цалин	179,930,710.40	177,591,043.00
210102	Нэмэгдэл	45,419,634.84	48,025,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,866,754.00	37,601,057.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,852,037.53	34,440,037.03
210201	Тэтгэврийн даатгал	23,323,237.53	23,911,297.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,632,300.00	2,632,240.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,105,800.00	2,105,800.00
210204	Ажигүйдлийн даатгал	526,400.00	534,802.48
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,300.00	5,255,897.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,288,200.00	56,415,053.91
210301	Гэрэл, цахилгаан	11,337,557.00	11,056,303.91
210302	Тулш, халаалт	48,700,643.00	45,108,750.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,016,100.00	23,360,300.00
210401	Бичиг хэрэг	6,057,400.00	4,096,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,351,700.00	13,584,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,607,000.00	1,680,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	4,000,000.00
2105	Нормативт зардал	750,000.00	703,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	703,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,400,000.00	5,825,375.00
210604	Урсгал засвар	10,400,000.00	5,825,375.00
2107	Томилолт, зочны зардал	2,429,000.00	2,258,000.00
210702	Дотоод албан томилолт	2,429,000.00	2,258,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,809,690.00	47,453,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,297,690.00	45,941,948.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280,000.00	280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,616,250.00	112,802,887.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,616,250.00	112,802,887.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,613,771.03	53,236,671.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,487,200.00	19,037,693.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,415,500.00	17,037,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,071,700.00	1,999,993.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,126,571.03	34,198,978.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,126,571.03	34,198,978.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	108,057,400.00	64,993,555.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	108,057,400.00	64,993,555.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	108,057,400.00	64,993,555.00
2200	Дотоод эх үүсвэрээр	108,057,400.00	64,993,555.00
220001	Барилга байгууламж	00.00	18,220,493.00
221001	Их засвар	4,533,600.00	846,000.00
222001	Тоног төхөөрөмж	4,055,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	20,282,100.00	3,354,337.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	00.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,186,700.00	42,572,725.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-108,057,400.00	-64,993,555.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	515,110,300.00	508,078,036.77	507,558,000.00	502,481,383.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,675,900.00	477,398,536.77	483,148,000.00	478,071,383.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459,760,400.00	471,483,836.77	464,610,300.00	459,533,690.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,217,100.00	263,217,099.24	263,217,100.00	263,217,100.00
210101	Үндсэн цалин	177,230,000.00	177,845,420.40	177,230,000.00	177,591,043.00
210102	Нэмэгдэл	48,025,000.00	47,430,358.84	48,025,000.00	48,025,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,962,100.00	37,941,320.00	37,962,100.00	37,601,057.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,534,400.00	33,852,037.53	35,534,400.00	34,440,037.03
210201	Тэтгэврийн даатгал	25,005,600.00	23,323,237.53	25,005,600.00	23,911,297.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,632,300.00	2,632,300.00	2,632,300.00	2,632,240.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,105,800.00	2,105,800.00	2,105,800.00	2,105,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	526,400.00	526,400.00	526,400.00	534,802.48
210205	Эрүүл мэндийн даатгал	5,264,300.00	5,264,300.00	5,264,300.00	5,255,897.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,488,200.00	60,288,200.00	59,488,200.00	59,415,053.91
210301	Гэрэл, цахилгаан	11,038,000.00	11,337,557.00	11,038,000.00	11,056,303.91
210302	Түлш, халаалт	49,200,200.00	48,700,643.00	48,200,200.00	48,108,750.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,017,100.00	23,016,100.00	23,380,300.00	23,380,300.00
210401	Бичиг хэрэг	6,057,400.00	6,057,400.00	4,501,300.00	4,096,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,351,700.00	15,351,700.00	13,179,000.00	13,584,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,608,000.00	1,607,000.00	1,700,000.00	1,700,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ари	-	-	4,000,000.00	4,000,000.00
2105	Нормативт зардал	750,000.00	750,000.00	703,700.00	703,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	750,000.00	703,700.00	703,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	10,400,000.00	7,000,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	10,400,000.00	7,000,000.00	7,000,000.00
2107	Томилот, зочны зардал	5,977,100.00	2,429,000.00	5,977,100.00	2,258,000.00
210702	Дотоод албан томилот	5,977,100.00	2,429,000.00	5,977,100.00	2,258,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,512,000.00	11,512,000.00	6,512,000.00	6,512,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	10,000,000.00	5,000,000.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	400,000.00	400,000.00	400,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280,000.00	280,000.00	280,000.00	280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,264,500.00	47,264,500.00	62,797,500.00	62,607,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,264,500.00	47,264,500.00	62,797,500.00	62,607,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,915,500.00	5,914,700.00	18,537,700.00	18,537,693.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,915,500.00	5,914,700.00	18,537,700.00	18,537,693.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,415,500.00	4,415,500.00	17,037,700.00	17,037,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,499,200.00	1,500,000.00	1,499,993.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,434,400.00	30,679,500.00	24,410,000.00	24,410,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,434,400.00	30,679,500.00	24,410,000.00	24,410,000.00
220001	Барилга байгууламж	-	-	20,652,200.00	20,209,663.00
221001	Их засвар	10,397,400.00	10,397,400.00	-	846,000.00
222001	Тоног төхөөрөмж	18,754,900.00	18,754,900.00	-	-
223001	Бусад хөрөнгө	20,282,100.00	20,282,100.00	3,757,800.00	3,354,337.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	513,545,000.00	513,545,000.00	507,558,000.00	507,558,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	513,545,000.00	513,545,000.00	507,558,000.00	507,558,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	513,545,000.00	513,545,000.00	507,558,000.00	507,558,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25	25	25
620001	Удирдах ажилтан	08	08	08	08
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	10	10
620003	Үйлчлэх ажилтан	02	02	02	02
620004	Гэрээт ажилтан	05	05	05	05

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117,844,940.00	128,026,265.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,844,940.00	128,026,265.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,144,940.00	127,526,265.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,297,690.00	56,290,048.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,297,690.00	56,290,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,847,250.00	71,236,217.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,847,250.00	71,236,217.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,700,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,700,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,700,000.00	500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,504,547.80	157,148,627.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,504,547.80	157,148,627.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	34,885,350.00	80,750,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,725,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,316,697.80	22,290,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,877,500.00	54,107,877.70
131106	Төсвийн урамшуулал	12,700,000.00	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар иргэдийнхээ сайн сайхны төлөө тэдний амьдралын чанарыг байнга дээшлүүлэх боломжоор хангаж сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх төрийн захиргааны байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засаг даргын захирамжаар дотоод хяналт шалгалтын 5 гишүүнээс бүрдсэн ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тооцон хэрэгжилтийн явцыг улирал бүр Засаг даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулж ажилладаг байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж нийт 14,681.0 мянган төгрөгийн зөрчил

илэрснээс 13,384.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,297.0 мянган төгрөгийн 1 акт тогтоосныг 100% барагдуулсан байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 746,193.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,192.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,394.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 27,608.7 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 16,415.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцов.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт зарлага 746,193.4 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны зарлага 1,840,579.4 мянган төгрөг, 1,094,386.0 мянган төгрөгөөр орлого нэмэгдсэн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газарт мөрдөгдөх Нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 507,558.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 92,117.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 157,148.6 мянган төгрөг нийт 756,824.5 мянган төгрөг өмнөх оноос 10,490,400.4 мянган төгрөгөөр буюу 13.9 дахин буурсан байна.

Зардал :

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,840,579.4 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 565,514.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 502,481.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141055001 тоот дансанд 2021 онд 507,558.0 мянган төгрөгийн орлого, 507,558.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 100141055401 тоот дансанд 157,148.6 мянган төгрөгийн орлого, 157,148.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	17,905.8	23,000.0	-5,094.2
Урьдчилгаа			
Бараа материал	58,711.1	63,619.9	-4,908.8
Үндсэн хөрөнгө	12,197,750.4	10,845,700.1	1,352,050.3
Нийт хөрөнгө	12,274,367.3	10,932,320.1	1,342,047.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	12,274,367.3	10,932,320.1	1,342,047.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,274,367.3	10,932,320.1	1,342,047.2

Авлага дансны оны эхний үлдэгдэл 17,905.8 мянган төгрөгийг барагдуулж, оны эцсийн үлдэгдэл 23,000.0 мянган төгрөг нь хүүхдийн тоглоомын талбай тохижуулахад 14,000.0 мянган төгрөг, чацарганы талбайн хашаа 9,000.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу, ажил хүлээж аваагүйгээс авлагаар тусгаснаас нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63,619.9 мянган төгрөг болж 4,908.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,845,700.1 мянган төгрөг болж 1,352,050.3 мянган төгрөгөөр буурсан нь акталсан хөрөнгө болон элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй болон шилжүүлэн авсан 77,589.8 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар худалдан авсан 42,572.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж акталж устгасан 285,294.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,932,320.1 мянган төгрөг болж 1,342,047.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 491,502.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 491,502.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8,372.6 мянган төгрөгөөр бууруулж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 483,148.0 мянган төгрөгөөр ирүүлсэн саналын дагуу орон нутгийн төсвөөс 483,148.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр Алтанбулаг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан байна.

Тус байгууллагын төсвийг Алтанбулаг сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор шилжих үлдэгдлээс 24,410.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн 507,558.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 507,558.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 507,558.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 507,558.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 502,481.4 мянган төгрөгийг зарцуулж, 5,076.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 502,481.4 мянган төгрөг буюу 98.99 хувьтай байгаа нь 5,076.6 мянган төгрөг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хандиваар 80,750.0 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 22,290.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 54,107.9 мянган төгрөг нийт 157,148.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 56,290.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 71,236.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 500.0 мянган төгрөг нийт 128,026.3 мянган төгрөг зарцуулж, 29,122.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн зардлаас ХАУС хорооллын нийтийн талбайн хашаа барьж байгуулахад 14,070.0 мянган төгрөг, гэр хорооллын 34 ш гэрэлтүүлгийн засварын ажилд 9,669.0 мянган төгрөг, цамхагт гэрэлтүүлэгт 5,000.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах зардалд 11,278.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Тус байгууллага тайлант онд орон нутаг судлах музейн халаалтын дулааны шугам сүлжээний ажилд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 50,224.9 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар цамхагт гэрэлтүүлэгт 10,000.0 мянган төгрөг зарцуулж, Жо интернашнл ХХК Туул голын ойр орчмын ундны ус, булаг шандыг цэвэрлэх байгууламжийг бохирдлоос хамгаалж 50 метрийн өндөртэй, 4 метрийн өргөнтэй даланг босгох ажил, Баялаг ХХК Туул хорооны худгийг цахим худаг болгох ажлыг өөрийн хөрөнгөөр тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Тус байгууллага тайлант онд Азийн хөгжлийн банк, ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй хамтарсан багаас малчин эмэгтэйчүүдэд үзүүлэх нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ сайжруулах нь сэдэвтэй төсөлд 11,665.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч 9,730.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Ковид-19 цар тахалд 86 иргэнээс 24,940.0 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Бөхөг түргэн ХХК 10,000.0 мянган төгрөг, Бууралын ар булаг ХХК 10,000.0 мянган төгрөг, Итгэл түшиг ХХК 8,200.0 мянган төгрөг, Тэгшплант ХХК 3,000.0 мянган төгрөг, Хонгор холдинг ХХК 5,000.0 мянган төгрөг, Жотайн бажууна ХХК 20,000.0 мянган төгрөгийг хүүхдийн тоглоомын талбайн бүтээн байгуулалтад, био техникийн арга хэмжээний зардалд 610.0 мянган төгрөг хандив тусламжаар ирсэн байна.

Тус байгууллага нэмэлт санхүүжилтийн дансанд орсон хандивын 80,750.0 мянган төгрөгийн зарцуулах хүсэлтийг Засаг даргын Тамгын газрын даргын 8

удаагийн албан тоотоор Төв аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Сумын онцгой комиссын шатахуунд, ковид халдварт цар тахал, шүлхий өвчний зардалд 23,552.0 мянган төгрөг зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 110 мэдээлэл, хугацаа хоцроосон 22 мэдээлэл байна. Тус байгууллага зарлагын 5,0 саяас дээших орлогын 6 гүйлгээ, зарлагын 16 гүйлгээ, худалдан авалтын 11 гүйлгээ хугацаанд байршуулж, 5,0 саяас дээших орлогын 529,499.5 мянган төгрөгийн 19 гүйлгээ, зарлагын 8,698.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, худалдан авалтын 24,412.2 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 23,000.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн 2 шийдвэр хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага тайлант онд Коронавируст халдвар цар тахалтай холбогдуулан 86 иргэнээс өгсөн 24,940.0 мянган төгрөгийн хандивын мөнгийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг Улсын онцгой комисс болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд ил тод байлгаж, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд авч тайлагнасан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр, авлага, шилэн данстай холбоотой 2 зөвлөмж, мөнгөн кассын журамтай холбоотой 1 албан

шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 05/333 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 748,069.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 34,198.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 128,260.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 585,609.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.2.1 Залруулсан алдаа

Тус байгууллага тайлант оны мөнгөн гүйлгээний тайланд 34,198.9 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг тайлагнаагүйгээс нийт цэвэр мөнгөн гүйлгээг зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.3 Албан шаардлага

1.Худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 66,383.3 мянган төгрөгийн 26 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6 дах заалтыг зөрчин уралдаан тэмцээний шагнал, мянгант малчны гарын бэлэг дурсгалын зүйл, гэрлэлт батлах хүндэтгэлийн арга хэмжээ зэрэг зардлуудад 5,677.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3. Тус байгууллага тайлант онд нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Бөхөг түргэн ХХК 10,000.0 мянган төгрөг, Бууралын ар булаг ХХК 10,000.0 мянган төгрөг, Итгэл түшиг ХХК 8,200.0 мянган төгрөг, Тэгшплант ХХК 3,000.0 мянган төгрөг, Хонгор холдинг ХХК 5,000.0 мянган төгрөг, Жотайн бажууна ХХК 20,000.0 мянган төгрөг нийт 56,200.0 мянган төгрөгийн хандив тусламж авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно”, 25.5.1-д “хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх,” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй,” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 110 мэдээлэл, хугацаа хоцроосон 22 мэдээлэл байна. Тус байгууллага зарлагын 5,0 саяас дээших орлогын 6 гүйлгээ, зарлагын 16 гүйлгээ, худалдан авалтын 11 гүйлгээ хугацаанд байршуулж, 5,0 саяас дээших орлогын 529,499.5 мянган төгрөгийн 19 гүйлгээ, зарлагын 8,698.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, худалдан авалтын 24,412.2 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 23,000.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн 2 шийдвэр хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, “4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Алтанбулаг сумын ЗДТГ	4	162,459.6	1	34,198.9	0	0	3	128,260.7		
Дүн		4	162,459.6	1	34,198.9	0	0	3	128,260.7		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Алтанбулаг сумын ЗДТГ	1	585,609.7							1	585,609.7
Дүн		1	585,609.7							1	585,609.7
Нийт дүн		5	748,069.3	1	34,198.9	0	0	3	128,260.7	1	585,609.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn